



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2024 оны 03 сарын 19 өдөр

Дугаар A/133

Улаанбаатар хот


Г Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3 дахь заалт, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь заалт, Засгийн газрын 2022 оны "Журам батлах тухай" 497 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Шинжлэх ухаан, технологийн сангаас тэтгэлэг олгох, сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам" -ын 6.1 дэх хэсэг, "Төрөөс шинжлэх ухаан, технологийн салбарын талаар баримталж буй бодлогын хэрэгжилт, үр нөлөө гүйцэтгэлийн аудитаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Шинжлэх ухаан, технологийн төслийн төсөвт өртгийг тодорхойлох, түүний зарцуулалтад санхүүгийн хяналт тавих журам"-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологийн бодлого, инновацийн хөгжүүлэлт, хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Баттогтох/, Шинжлэх ухаан, технологийн сан /Д.Одгэрэл/ нарт үүрэг болгосугай.
3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2016 оны "Журам батлах тухай" А/319 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Л.ЭНХ-АМГАЛАН



Боловсрол, шинжлэх ухааны сайдын
2024 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн
A/133 тоот тушаалын хавсралт

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТӨСЛИЙН ТӨСӨВТ
ӨРТГИЙГ ТОДОРХОЙЛОХ, ТҮҮНИЙ ЗАРЦУУЛАЛТАД
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмаар шинжлэх ухаан, технологийн төслийн төсөвт өртөг, зардлыг тодорхойлох, хянах, төслийн санхүүжилтийн хэмжээг тогтоох, түүний зарцуулалтад хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1.2. Шинжлэх ухаан, технологийн төсөл дэвшүүлэгчийн тодорхойлсон өртөг, зардлын тооцоо нь тухайн төслийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд төслийн санхүүжилтийн хэмжээг тогтоох үндэслэл болно.

1.3. Журамд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.3.1. Шинжлэх ухаан, технологийн төсөл" /цаашид "төсөл" гэх/ гэж "Шинжлэх ухаан, технологийн сангаас тэтгэлэг олгох, сангийн хөрөнгийг зарцуулах, журам" -ын 3.5.1-3.5.7 заасныг;

1.3.2. "төсөл дэвшүүлэгч" гэж төсөл хэрэгжүүлэх зорилгоор төслийн баримт бичгийг санаачлан боловсруулж, шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад ирүүлсэн иргэн, хуулийн этгээдийг;

1.3.3. "төслийн төсөвт өртөг" гэж тухайн төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай өртгийг мөнгөн дүнгээр илэрхийлснийг;

1.3.4. "төслийн санхүүжилт" гэж тухайн төслийг хэрэгжүүлэхээр шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас баталсан мөнгөн хөрөнгийг.

1.4. Төслийн төсөвт өртөг, зардлыг тодорхойлоход дор дурдсан зарчмыг баримтална:

1.4.1. зах зээлийн үнэ ханшид сууринсан байх;

1.4.2. үр ашигтай, хэмнэлттэй байх;

1.4.3. холбогдох хууль, эрх зүйн баримт бичигт нийцүүлэн боловсруулсан байх.

Хоёр. Төслийн төсөвт өртөг, зардлыг тодорхойлох

2.1. Төсөл дэвшүүлэгч нь төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг тодорхойлоходоо Засгийн газраас баталсан "Шинжлэх ухаан, технологийн сангаас тэтгэлэг олгох, сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам"-ын 3.10-д заасны дагуу Шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр баталсан төсөл, арга хэмжээний саналын бүрдэлтэй уялдуулна.

2.2. Төслийн төсөвт өртгийг тодорхойлоходоо дор дурдсаныг үндэслэл болгоно.

2.2.1. Үндсэн болон гэрээт ажилтны цалин, хөлсийг тооцоходоо Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжид заасан албан татвар, хураамж, Засгийн газраас тогтоосон цалин хөлсний сүлжээг;

2.2.2. Дотоод, гадаад томилолтын зардлыг эрх бүхий байгууллагаас тогтоосон хэмжээгээр;

2.2.3. Бараа, ажил, үйлчилгээг хууль тогтоомжид заасны дагуу худалдан авахад зах зээлийн тухайн үеийн валютын ханшийг;

2.3. Төслийн төсөвт өртөгт үндсэн, гэрээт болон ахисан түвшинд суралцагчдын цалин хөлсний эзлэх хувь 30-аас ихгүй байна.

Гурав. Төслийн төсөвт өртгийг тодорхойлох

3.1. Төслийн төсөвт өртгийг тодорхойлоходоо доорх шалгуурыг баримтална.

3.1.1. Төслийн зардлыг энэхүү журмын хавсралтаар баталсан “Төслийн санхүүжилтэд эзлэх эрдэм шинжилгээний зардлын ангиллын доод хязгаар /хувиар/, бусад зардлын ангилал, задаргаа”-г баримталсан эсэх;

3.1.2. төслийн зардлыг үнэн зөв, бодитойгоор тооцоолсон эсэх;

3.1.3. төслийн зардал нь төслөөс гарах үр дүнтэй уялдаж буй эсэх;

3.2. Төслийн төсөвт өртгийн зардлын тооцоог үндэслэл муутай, үр дүнгийн даалгавартай уялдаагүй гэж үзвэл мэргэжлийн зөвлөлд төслийг хэрэгжүүлэхээс татгалзах санал оруулна.

3.3. Төслийн төсөвт өртгийн зардалд их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудын лаборатори, судалгаа-туршилтын бааз, багаж, тоног төхөөрөмжийг ашигласны шимтгэлийг тооцохгүй.

Дөрөв. Төслийн санхүүжилтийн зарцуулалтад санхүүгийн хяналт тавих, хариуцлага тооцох

4.1. Төслийн санхүүжилтийн зарцуулалт, үр дүнгийн хэрэгжилтийн явц, гүйцэтгэлд санхүүжүүлэгч болон захиалагч байгууллага хамтын хяналт тавина. Үүнд:

4.1.1 санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэх

4.1.2. санхүүгийн баримт бичгийн бүрдүүлэлт, тайлагнал

4.1.3. төслийн хүрээнд өр төлбөр үүссэн эсэх, учир шалтгаан

4.1.4. эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжилтийн хувьд эргэн төлөлтийн байдал.

4.2 Төрийн өмчийн их дээд сургууль болон эрдэм шинжилгээний хүрээлэн, төвүүдийн хувьд хэрэгжиж байгаа төслийн мөнгөн урьдчилгааны тайланг гарган Шинжлэх, ухаан технологийн санд хагас, бүтэн жилээр хүргүүлж тооцоо нийлж акт үйлдэнэ.

4.3 Энэ журмын 4.2 –т зааснаас бусад төсөл хэрэгжүүлэгч нь хагас, бүтэн жилээр гаргасан санхүүгийн зарцуулалтын тайланг анхан шатны баримтын хамт Шинжлэх ухаан технологийн санд ирүүлнэ.

4.4 Шинжлэх ухаан, технологийн сан нь төслийн үр дүнгийн болон санхүүгийн тайлан, тооцоо нийлсэн актыг хүлээн авч, шаардлага хангасан тохиолдолд дараагийн санхүүжилтийг олгоно.

4.5. Гүйцэтгэгч төслийн санхүүжилтийг зориулалтын бус зүйлд зарцуулсан, шалгалтын явцад илэрсэн зөрчил нь тодруулах шаардлагатай, гэмт хэргийн шинжтэй

гэж үзвэл хууль хяналтын байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.

4.6. Төсөл санхүүжүүлэхтэй холбогdon үүссэн маргааныг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн сангаас тэтгэлэг олгох, сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам, Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх гэрээ болон бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ.

---оо---

Шинжлэх ухаан, технологийн төслийн төсөвт өргтийг тодорхойлох, түүний зарцуулалтад санхүүгийн хяналт тавих журмын хавсралт

Төслийн санхүүжилтэд эзлэх Эрдэм шинжилгээний зардлын ангиллын доод хязгаар /хувиар/, бусад зардлын ангилал, задаргаа

№	Зардлын ангилал,	Зардлын задаргаа	Суурь судалгааны төсөл	Захиалгат төсөл	Цөм технологийн төсөл	Технологийн туршилт зүгшруулэлт ийн төсөл	Хавсарга судалгааны төсөл
1.	Эрдэм шинжилгээний зардал	Эрдэм шинжилгээний хурал, семинар, үзэсгэлэн зохион байгуулах зардал /хурлын заал болон тоног төхөөрөмжийн түрээс г.м/	45	40	35	30	30
		Гадаад болон дотоодын сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх зардал					
		Судалгааны ажлын тайлан бичихтэй холбогдсон зардал /бичиг хэрэг хэвлүүлэх г.м/					
		Урвалж бодис худалдан авах зардал					
		Туршилтын мал амьтан худалдан авах, устгаж аюулгүй болгох зардал					
		Патентын төлбөр /тухайн судалгааны ажилтай холбогдох/					
		Оюуны өмчийн үнэлгээний зардал					
		Ургамлын үр сорт худалдан авах зардал					
		Микро организм, өсгөвөр худалдан авах зардал					
		Гишүүнчлэлийн төлбөр					
		Хөдөлмөр хамгааллын зардал					
		Дотоодын томилолтын зардал					
		Социологийн болон түүвэр судалгааны зардал					
		Хээрийн хайгуул, малтлага судалгааны зардал					
4	Гадаад, дотоод томилолтын зардал	Гадаад томилолт					
		Гадаадын эрдэмтэн судлаачдыг Монголд байх хугацааны үйлчилгээний зардал					
5	Тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээ	Компьютер, түүний программ хангамж, дагалдах тоног төхөөрөмж худалдан авах, засвар үйлчилгээ хийх зардал					
		Судалгааны тоног төхөөрөмжийн хэмжилт, сууринуулалт, засвар үйлчилгээний зардал					
		Туршилтын цех, үйлдвэрийн болон лабораторийн тоног төхөөрөмжийг худалдан авах зардал					
		Сэлбэг хэрэгсэл, лабораторийн хэрэгсэл худалдан авах зардал					
		Мэдээлэл худалдан авах зардал					

		Бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	Орчуулгын зардал					
			Ном бүтээлийн хэвлэлийн эх бэлтгэл, хэвлэлийн зардал					
			Дээж авчрах, шинжлүүлэх зардал					
			Олон улсын хурлын төлбөр /тухайн судалгааны ажилтай холбогдох					
			Төслийн явц, үр дүнд хяналт шинжилгээ хийх зардал					

—оOо—